



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 16

Есөнбулаг сум

**Хөрөнгө бүртгэж, данснаас хасахыг
зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 25 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.4 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны хөрөнгөд бүртгэлтэй Ландкрузер Прадо 120 маркийн ГАА 01-23 улсын дугаартай суудлын автомашин нь осол гэмтэлд орсны улмаас цаашид ашиглах боломжгүй болсон тул акталж, данснаас хасч, “Ард даатгал” ХХК-ийн салбараас даатгалын нөхөн төлбөрт өгсөн Ландкрузер 100 маркийн ГАУ 00-02 улсын дугаартай суудлын автомашиныг тус ажлын албаны баланс хөрөнгийн бүртгэлд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын алба, “Ард даатгал” ХХК-ийн салбаруудын хооронд байгуулсан даатгалын гэрээний 13 дугаар зүйлийн 13.2.3 –т заасны дагуу актлагдаж буй Ландкрузер Прадо 120 маркийн ГАА 01-23 улсын дугаартай суудлын автомашиныг “Ард даатгал” ХХК-ийн салбарт хүлээлгэн өгөхийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай.

3. Актлагдсан болон шинээр орон нутгийн өмчид бүртгэж авч буй автомашинуудын хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, комисс томилон хүлээлцэн, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Орон нутгийн өмчийн газарт даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ

